

48

**УЛААНБААТАР ХОТЫН НАМЫН ХОРОО**  
**АДХ—ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ**  
**ТОГТООЛ**

*Улаанбаатар хот*

1987 оны 7 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 220

Залуучуудын орон сууцны цогцолбор  
/ЗОСЦ/ байгуулах санаачилгыг дэмжих  
тухай

Залуучуудын соёл ахуйн нөхцөлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийг нь идэвхтэй оролцуулах, хамтран амьдрах, социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх зорилгоор нийслэл хотод ЗОСЦ барих ажлыг БХДКЗЭ-ийн туршлагаар туршин нэвтрүүлэх тухай Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хорооны санаачилгыг дэмжин Улаанбаатар хотын намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотод Үш таван мэлд 10000 ам метр сууцны талбай бүхий залуучуудын орон сууцны цогцолбор /ЗОСЦ/ байгуулах тухай залуучуудын саналыг дэмжин 1987 оны IY улирлаас эхлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Улаанбаатар хотод ЗОСЦ байгуулахтай холбогдуулан ЗОСЦ-ын ерөнхий захиалагчийн үүргийг гүйцэтгэхийн хамт дэргэдээ ЗОСЦ-ын штаб, барилга захиалагчийн группийг байгуулах ажлыг хотын ХЗЭ-ийн хороо /н.Энхмандах/-нд даалгасугай.

3. ЗОСЦ-ыг барих газрыг Найрамдын районы ОСТ-ны 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт хавсралт схемийн дагуу байрлуулж 15,4 га газар олгосугай.

4. 1988 онд ашиглалтад оруулах II-р хорооллын I-р барилгын нэг секц 36 айлын орон сууцны барилгыг ЗОСЦ-ын анхны отрядтай хамтран барьж МХЗЭ-ийн XIX их хурлын өмнө ашиглалтанд оруулахыг хотын ХЗЭ-ийн хороо ш/н.Энхмандах/, Угсармал барилга үйлдвэрлэлийн нэгдэл /н.Мадамбаа/-д даалгасугай.

5. Хотын ХЗЭ-ийн хорооны дэргэдэх ЗОСЦ-ын штабаар доорх ажлуудыг 1988 оны I улиралд багтаан гүйцэтгүүлэхийг хотын ХЗЭ-ийн хороо /н.Энхмандах/- д даалгасугай. Үүнд:

а/ЗОСЦ байгуулах ажлын журам, удирдамж, эвлэл залуучуудын барилгын отряд /ЭЗБӨ/-ийн дайчдыг барилгын мэргэжлээр сургах, дадлагажуулах программ боловсруулж мөрдөх;

б/олгогдсон эдэлбэр газарт иргэцолборыг байгуулахад шаардлагатай итжөнөрийн геологи, зураглал, хайгуулын ажлыг Улсын геодези зураг зүйн газар, Барилгын итжөнөр хайгуул, үйлдвэрлэл шигжилгээний институттай хамтран шийдвэрлэх;

6. ЗОСЦ-ын орон сууцны барилга байгууламжийг ЗОСЦ-д оролцож буй залуучуудын ажиллаж байгаа үйлдвэр, албан газар, байгууллагуудаас хувь нэмлүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

7. ЗОСЦ-ын эхний ээлжийн барилга байгууламжийг санхүүжилтэнд орон сууц худалдсан хөрөнгөөс тусламжаа үзүүлэхийг санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

8. ЗОСЦ-ын орон сууц хөрөнгийн доторхи итжөнөрийн дугам сүлжээ, зам талсан, соёл ахуйн үйлчилгээний зориулалттай барилга, төвлөрсөн шугам сүлжээ болон ЗОСЦ-д төсөвт байгууллагын залуучууд оролцсон тохиолдолд орон сууцны улсын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх зэрэг асуудлыг боловсруулж, холбогдох дээд байгууллагад оруулж шийдвэрлүүлэхийг хотын ХЗЭ-ийн хороо /н.Энхмандах/, Иж барилгын хэлтэс /н.Нэргүй/-д даалгасугай.

9. ЗОСЦ барьж байгууламсад шаардлагатай барилгын хийц эдэлхүүнийг талсаард эхнээж олох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Иж барилгын хэлтэс /н.Нэргүй/-т даалгасугай.

10. Хотын ХЗЭ-ийн хорооны захиалагчийн группийн боловсруулсан ЗОСЦ-ын барилга байгууламжуудыг барихтай холбогдон гарах хөрөнгө, материалын захиалгыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хянаж, төлөвлөгөөнд тусгах байхыг Төлөвлөгөөний комисс

/н.Ганбаатар/, Их барилгын хэлтэс /н.Нэргүй/-т даалгасугай.

11. Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хорооны дэргэдэх залуу инженер-архитекторчдын зөвлөл /ЗНАЗ/-ийг мэргэжлийн удирдлагаар болон шаардлагатай материал, техник хэрэгсэл, ажиллах боломжоор хангаж, зураг төслийн техникийн шийдлийг хянан баталж ажиллахыг Улсын барилгын зургийн төв институт /н.Бат/, Хөдөө аж ахуйн барилгын зургийн институт /п.Далчойнхор/, Архитектур төлөвлөлтийн газар /ч.Мадамбаа/, хотын ХЗЭ-ийн хороо /н.Энхмандах/-нд даалгасугай.

12. Цогцолбор барих ажлын хөрөнгө оруулалтыг хувь нийлүүлэгч үйлдвэр, аж ахуйн байгууллагуудаас төвлөрүүлэн санхүүжүүлэх тусгай дансыг ЗОСЦ-д нээж ажиллуулахыг хотын банкны контор /н.Цэрэндорж/-т даалгасугай.

13. ЗОСЦ-д ажиллах эргэлт-залуучуудыг барилгын отряд /ЗЭДО/-ын дагуу төрийн эзэмийн амралтаас гадна МААН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарийн зөвлөлгөөний 1979 оны 108 дугаар тогтоолыг үндэслэн 1-3 сар хүртэл хугацааны цалингүй чөлөө олгож байх эрхийг хувь нийлүүлэгч байгууллагуудын дарга нарт олгосугай.

14. ЗОСЦ-ын барилгыг барихад мэргэжлийн удирдлагаар хангаж, ЗОСЦ-ын штабтай гэрээ байгуулан ажиллах нь гүйцэтгэлээр цалинуудыг ажиллахыг Угсармал орон сууцны барилгын үйлдвэрлэлийн нэгдэл /ч.Мадамбаа/, хотын барилга трест /ч.Мамъян/, цогцолборыг байгуулахад шаардагдах машин механизмгаар графикийн дагуу хангаж ажиллахыг Барилгын машин механизмын бааз /ч.Дугар/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН

НААЙН ХОРООНЫ НЭГДЭГЭЭ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ЛАТЛУУ

АЖААНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ДААНЫ ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ